***Төлөвлөгөөний биелэлт үнэлсэн:*** ***Төсвийн Төвлөрүүлэн захирагч***

НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА ......................... Л.МӨНХЗУЛ

*(гарын үсэг)*

*Тэмдэг*

.......................
*(огноо)*

***Төлөвлөгөөний биелэлт тайлагнасан*** *:* ***Төсвийн шууд захирагч***

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГА ......................... Ш.АРИУНТУЯА

*(гарын үсэг)*

.......................
*(огноо)*

**БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН**
**2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| ***Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт.*** | | | | | | | |
| Нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын төв, орон нутгийн нэгжийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын дунд хугацааны төсвийн төсөл, төсөөлөл болон төсвийн нарийвчилсан хуваарийн санал боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих, судалгаа хийх, ирээдүйн төлөв байдал, урт хугацааны урьдчилсан тооцоолол хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, санал боловсруулах | | | | | | | |
| 1.1.1. | Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан дүрэм, журам, дээд газраас ирүүлсэн заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг зохион байгуулах. | Шаард-лагагүй | Хэрэгжүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн тоо | Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой Нийгмийн Даатгалын Ерөнхий Газраас 2023 онд ирүүлсэн 12 удаагийн зөвлөмжийн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан. | Дээд газраас ирүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж, үр дүнг тооцож ажилласан байна. | Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан дүрэм, журам, дээд газраас ирүүлсэн заавар, зөвлөмж 2023 онд ирүүлсэн 12, 2024 оны эхний хагас жилийн байдлаар 8 зөвлөмж, 3 дүрэм, 13 журмыг хэрэгжүүлэн ажиллаж байна. | 100 хувь |
| 1.1.2. | Сайн дурын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх, албан бус хөдөлмөр эрхлэгчдийг сайн дурын даатгалд шинээр хамруулах, хамралтын төлөвлөгөөг биелүүлэх | Шаард-лагагүй | Сайн дурын даатгалд шинээр хамруулсан даатгуулагчийн тоо, | 2023 оны эхний хагас жилд шинээр 2883 иргэнийг сайн дурын даатгалд хамруулсан байна. | 2024 оны эхний хагас жилд сайн дурын даатгалд шинээр 2133 даатгуулагч, 0-3 насны хүүхдээ асарч буй ээж 184, малчин 17, | Нийгмийн Даатгалын Ерөнхий Газраас 2024 оныг хамралтыг нэмэгдүүлэх жил болгон зарласантай холбоотойгоор болзолт уралдааныг зарлан хэрэгжүүлж ажиллаж байна. Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй их дээд | 102.8 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ажлыг зохион байгуулах, биелэлтийг тогтоосон хугацаанд хүргүүлэх. | | дээд газарт хүргүүлсэн мэдээ, тайлангийн тоо | | хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй эцэг, эх 545 нийт 2879 даатгуулагч шинээр хамруулсан байх | сургууль болон зах худалдааны төвүүдээр сар тутамд хуваарь гарган ажиллаж, оюутан суралцагсад болон хувиараа хөдөлмөр эрхэлдэг иргэдэд эрүүл мэнд, сайн дурын даатгалд хамрагдахын ач холбогдлын талаар мэдээлэл өгөн ажиллан хамрагдалтыг нэмэгдүүлж, төлөвлөгөөг биелүүлэн ажиллаж байна. Санхүүгийн дэмжлэг хүссэн иргэд, ажил олгогчдыг нийгмийн даатгалд хамруулах, авлагыг барагдуулах, Нийгмийн даатгалын ач холбогдлыг таниулах ажлыг дүүргийн Хөдөлмөр Халамж Үйлчилгээний Газартай хамтран зохион байгуулж, 6 дугаар сарын 14-нд сургалт хийлээ. 2024 оны эхний хагас жилд энгийн сайн дурын даатгалд 2395, 0-3 насны хүүхдээ асарч буй ээж 185, малчин 15, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асар буй эцэг эх 284 хамруулсан байна. | |
| 1.1.3. | Албан журмын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор нийгмийн даатгалд хамрагдаагүй ажил олгогч, даатгуулагчдыг шинээр хамруулах, хамралтын | Шаард-лагагүй | Албан журмын даатгалд шинээр хамрагдсан ажил олгогч, албан | 2023 оны эхний хагас жилд 408 ажил олгогч, 1686 албан журмын даатгуулагч | 2024 оны эхний хагас жилд албан журмын даатгалд шинээр ажил олгогч 453, албан журмын даатгуулагч 1862 | 2024 оны эхний хагас жилд ажил олгогчийн тоог 458, даатгуулагчийн тоог 1875 нэмэгдүүлж, төлөвлөгөөг биелүүлсэн байна. | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | төлөвлөгөөг биелүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтийг тогтоосон хугацаанд хүргүүлэх. | | журмын даатгуулагчийн тоо | шинээр хамруулсан. | хамруулсан байх. | | |
| ***Хоёр. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт*** | | | | | | | |
| Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлыг хугацаанд нь олгох, өр, авлага барагдуулах ажлыг удирдан зохион байгуулах, өмчийн харилцаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, нийгмийн даатгалын сангийн хуримтлал бий болгох, нягтлан бодох бүртгэлийн мэргэжил арга зүйгээр хангах, гүйцэтгэлийг тайлагнах | | | | | | | |
| 2.1.1. | Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын төсвийн нарийвчилсан хуваарь, сар, улирлын хуваарийг мөрдөж ажиллах. | Шаард-лагагүй | Нийгмийн даатгалын сангийн 2024 оны орлого 398’827.75 сая төгрөг, 539’445,5 сая төгрөгийн зарлагын төсөв батлагдсан. | Нийгмийн даатгалын санд 2023 онд 424’305.5 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардалд 430’271.49 сая төгрөг зарцуулсан. | Батлагдсан төсвийн хуваарь, дээд газраас ирүүлсэн зөвлөмж, чиглэлийг мөрдөж ажилласан байна. | НДЕГ-ын даргын А/03 тоот тушаалаар батлагдсан нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын төсвийн нарийвчилсан хуваарь, сар, улирлын хуваарийн дагуу үйл ажиллагаагаа явуулж байна. Тус дүүргийн сангийн орлогын төлөвлөгөө хагас жилээр 193363,9 сая төгрөгөөр батлагдсан бөгөөд 212198,7 сая төгрөгийн орлого бүрдүүлж ажилласан. Энэ нь 110 хувьд хүрч байна. Тэтгэмжийн даатгалын сангийн батлагдсан төлөвлөгөөний дагуу 11042,67 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон бөгөөд 12118,69 сая төгрөгийн зарцуулсан байна. Тэтгэврийн даатгалын сангийн төлөвлөгөөгөөр тэтгэврийн санд 237917,5 сая, үйлдвэрлэлийн ослын санд 2097,5 сая төгрөгийн төлөвлөгөөтэй санхүүжилт орж ирсэн бөгөөд тэтгэврийн даатгалын санд 243305,22 сая | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төгрөг, 1798,96 сая төгрөг үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас зарцуулагдсан. Ажилгүйдлийн даатгалын сангийн төлөвлөгөө 10549,3 сая төгрөг бөгөөд 9297,43 сая төгрөгийн зарцуулалттай байна. | |
| 2.1.2. | Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль, НДЕГ-ын даргын баталсан нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлын төсвийн нарийвчилсан хуваарь, сар, улирлын хуваарийг мөрдөж ажиллах. | Шаард-лагагүй | Нийгмийн даатгалын байгууллагын 2024 оны үйл ажиллагааны урсгал зардлын төсвийн гүйцэтгэл 2’343’941,0 сая төгрөг батлагдсан бөгөөд батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулна. | Нийгмийн даатгалын байгууллагын 2023 оны үйл ажиллагааны урсгал зардалд 1’894’204,7 сая төгрөг зарцуулсан. | Батлагдсан төсвийн хуваарь, дээд газраас ирүүлсэн зөвлөмж, чиглэлийг мөрдөж ажилласан байна. | НДЕГ-ын даргын 2024 оны А/03 дугаар “Үйл ажиллагааны урсгал зардлын 2024 оны төсвийн хуваарь батлах тухай” тушаалаар батлагдсан төсөвтэй танилцан байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллах зорилгоор бүлгийн дүнд багтаан эдийн засгийн ангиллаар нь зарцуулан ажиллаж байна. 2024 оны эхний хагас жилийн хугацаанд 1159,8 сая төгрөгийн батлагдсан төсөвтэй, санхүүжилт 100 хувь олгогдсон. Үүнээс 1107,3 сая төгрөг буюу 95,4 хувийн гүйцэтгэлтэйгээр Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан. | 100 хувь |
| 2.1.3. | Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн орлогын төлөвлөгөөг жигд хангаж биелүүлэх. | | Батлагдсан 317,409,904.3 төгрөгийн | 2023 оны эхний хагас жилд сангийн орлогын төлөвлөгөөг сар болон улирлаар | 2024 оны эхний хагас жилд Нийгмийн даатгалын шимтгэлийн | Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн орлогын төлөвлөгөөг жигд хангаж биелүүлж 179772,9 сая | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | шимтгэлийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг сараар, өссөнөөр жигд биелүүлэн ажиллана. | жигд хanган биелүүлж эхний хагас жилийн байдлаар 131103,8 сая төгрөг буюу 100,03 хувиар биелүүлэн ажилласан. | орлогын төлөвлөгөөг сар, улирал, жилээр жигд хanган биелүүлж, нийгмийн даатгалын санд 193304,2 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна. | төгрөгийн орлогыг төвлөрүүлэн ажиллалаа. | |
| 2.1.4. | Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас ирүүлсэн эрүүл мэндийн даатгалын сангийн ажил олгогчийн шимтгэлийн орлогын төлөвлөгөөг жигд хanган биелүүлэх. | | Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас ирүүлсэн орлогын төлөвлөгөө биелсэн байна. | 2023 оны эхний хагас жилд эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлогыг 25791.1 сая төгрөгөөр биелүүлэн ажилласан. | 2024 оны эхний хагас жилд Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө 40162,7 сая төгрөг буюу 100 хувь биелсэн байна. | Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас ирүүлсэн орлогын төлөвлөгөө 36832,8 сая төгрөгөөр буюу 91.7 хувиар биелсэн байна. | 91.7 хувь |
| 2.1.5. | Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг бууруулах ажлыг зохион байгуулж оны эхний үлдэгдэлээс бууруулах, үр дүнг тооцож газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, тайланг НДЕГ-т хүргүүлэх. | | Ажил олгогчоос төлөх шимтгэлийн авлагыг оны эхний дүнгээс 30-аас доошгүй хувиар бууруулна. | Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн авлага оны эхнээс 17.8 | Ажил олгогчоос төлөх шимтгэлийн авлагыг оны эхний дүнгээс 30-аас доошгүй | Хуримтлагдсан авлага барагдуулах 60 хоногийн аянг зарлан, байгууллагын өр, авлагын хэмжээ насжилтыг тодорхойлсон судалгааг гарган, тайлан шимтгэлийн авлага барагдуулах журмын дагуу арга хэмжээг шат дараалан авч, гадуур ажиллах хуваарь гарган өртэй ажил олгогчтой уулзалт хийн ажиллаж байна. 15086,1 сая төгрөгийн өртэй 275 ажил олгогчид авлага барагдуулах | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хувиар буурсан байна . | хувиар бууруулна. | тухай мэдэгдэл, 13874,4 сая төгрөгийн өртэй 371 ажил олгогчид улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлж, 14531 сая төгрөгийн өртэй 1236 ажил олгогчийн арилжааны банкин дах харилцах дансны зарлагын гүйлгээг хааж, 6901,3 сая төгрөгийн өртэй 132 ажил олгогчтой авлага барагдуулах гэрээг байгуулан ажилласан. Мөн 38 байгууллагын 6237,5 сая төгрөгийн авлагыг барагдуулахаар шүүхэд шилжүүлсэн, 360,8 сая төгрөгийн өртэй 6 байгууллагын хаягийг тодруулахаар эрэн сурвалжлахад шилжүүлсэн. Оны эхний авлага 59647сая төгрөг байснаас 649 ажил олгогчийн 2868,6 сая төгргйин авлагыг бүрэн барагдуулж, 444 ажил олгогчийн 4923,3 сая төгрөгийн авлагыг хэсэгчлэн барагдуулж, 1216 ажил олгогчийн 9886,2 сая төгрөгийн авлагыг баргдуулсан боловч шинээр нэмж шимтгэлийн авлага үүссэнг барагдуулахаар ажиллаж байна. | |
| 2.1.6. | Сайн дурын даатгуулагчийн нийгмийн даатгалын | | Сайн дурын даатгуула гчийн | Сайн дурын даатгуулагчийн шимтгэлийн | Сайн дурын даатгуулагчийн нийгмийн | Сайн дурын даатгуулагчийн өглөг 2024 оны эхнээс 10 хувиар бууруулан ажилласан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шимтгэлийн өглөгийг барагдуулах | | нийгмийн даатгалын шимтгэлийн өглөггүй гарсан байна. | өглөг 471 сая төгрөгтэй гарсан байна. | даатгалын шимтгэлийн өглөгийг бууруулж ажиллана. | | |
| 2.1.7. | Бусад өглөг, авлагыг барагдуулах | | Ажил олгогч, даатгуулагчийн шимтгэлийн өглөг авлагаас бусад өглөг, авлагыг хугацаанд нь барагдуулна. | Бусад өглөг авлага санхүүгийн тайлангаар 1141,61 сая төгрөгөөр баталгаажсан байна. | а) Нийгмийн даатгалын сангийн бусад өр, авлагыг оны эхний дүнгээс 50 хувиас доошгүй барагдуулах.<br>б) Нийгмийн даатгалын байгууллагын бусад өр, авлагыг бүрэн барагдуулах. | Нийгмийн даатгалын сангийн бусад өр, авлагыг оны эхний дүнгээс бууруулан ажиллаж байгаа бөгөөд тэтгэврийн даатгалын санд тавигдсан улсын байцаагчийн актын дагуу 101,96 сая төгрөгийн суутгал хийж авлага барагдуулсан. Тэтгэмжийн даатгалын сангийн авлагаас 77,9 сая төгрөгийг барагдуулсан. Мөн газрын даргын тушаалаар авлага барагдуулах комисс байгуулагдсан бөгөөд сангийн нягтлангууд хамтран авлага барагдуулах ажил зохион байгуулан ажиллаж байна.<br>Нийгмийн даатгалын хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх ААНБ-д хуулийн хэрэгжилтийг шалгах ажлын хүрээнд улсын байцаагчийн актаар тогтоосон нэр бүхий 12 ААНБ-тай холбоотой төгрөгийг 141,2 төгрөг, алданги 22,3 төгрөг 163,5 төлүүлж ажиллахаас 2024 оны эхний хагас жилийн байдлаар 1,3 сая төгрөгийг | 60 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төлүүлсэн мөн 0,6 сая төгрөгийн төлбөрийг хүчингүй болгуулахаар НДЕГ-т санал хүргүүлж ажилласан байна.<br>Тэтгэврийн даатгалын сангаас үндэслэлгүй олгосон тэтгэврийг санд төлүүлэх 61 хүний 825,1 сая төгрөгөөс 2024 оны эхний хагас жилийн байдлаар 212,2 төгрөг төлүүлсэн, тэтгэмжийн даатгалын санд 2 хүний 14,6 сая төгрөг төлүүлэхээс 1,7 сая төгрөгийг санд төлүүлсэн 1 даатгуулагчийн төлбөр зөрчлийн асуудал шүүхийн журмаар шийдвэрлүүлэхээр ажиллаж байна. Мөн ажилгүйдлийн даатгалын сангийн төлбөр, зөрчил 23 хүнтэй холбоотой 17,7 сая төгрөг төлүүлэхээс 2,3 сая төгрөг нийт 216,2 сая төгрөгийн төлбөр зөрчлийг барагдуулж ажилласан байна. | |
| 2.1.8. | НДЕГ-ын даргын 2023.12.26-ны өдрийн А/183 тоот тушаалаар батлагдсан “Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх, хуваарилах, санхүүжилт олгох, хяналт тавих журам”-ын 3.3 дах заалтыг хэрэгжүүлж ажиллах. | | НДЕГ-ын төвлөрсөн орлогын харилцах дансанд өдөр бүр бүрэн төвлөрүүлнэ. | НДЕГ-аас ирүүлсэн заавар журмын дагуу орлогын харилцах дансанд 7 хоног бүр төвлөрүүлэлтийг хийж ажилласан. | НДЕГ-ын төвлөрсөн орлогын харилцах дансанд өдөр бүр бүрэн төвлөрүүлсэн байна. | Нийгмийн даатгалын ерөнхий газрын Санхүү бүртгэлийн газрын даргын 2023.12.27-ны өдрийн тушаалаар 2024 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн нийгмийн даатгалын сангийн төвлөрсөн орлогын дансны үлдэгдлийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын төвлөрсөн орлогын харилцах дансанд өдөр бүр төвлөрүүлнэ гэсний дагуу 5 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сарын 31-ний байдлаар нийт 177870,1 сая төгрөг төвлөрүүлэн ажилласан. | |
| 2.1.9. | Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулах. | | Хууль тогтоомжийн дагуу иргэд даатгуулагчдад 487’326,31 сая төгрөгийн тэтгэвэр, 24’619,90 сая төгрөгийн тэтгэмж төлбөр зардлыг хугацаанд нь олгоно. | Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулсан ба Хууль тогтоомжийн дагуу иргэд даатгуулагчдад 384’086,48 сая төгрөгийн тэтгэвэр, 20’882,17 сая төгрөгийн тэтгэмж төлбөр зардлыг хугацаанд нь олгосон. | а) Тэтгэврийг сар бүрийн 01-ний өдөр олгох<br>б) Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төсвийн дагуу 511’932,88 сая төгрөгийг хуульд заасан хугацаанд зарцуулсан байна. | Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төлөвлөгөө болон орж ирсэн санхүүжилтийн дагуу зарцуулж байгаа бөгөөд эхний 5 сарын гүйцэтгэлээр тэтгэврийн сангийн төлөвлөгөө 196329,67 сая төгрөг, гүйцэтгэл 199666,10 сая төгрөг буюу 3336,43 сая төгрөгийн хэтрэлттэй байна. Тэтгэмжийн даатгалын сангийн төлөвлөгөө 11041,31 сая төгрөг, гүйцэтгэл нь 12418,23 сая төгрөг байна. ҮОМШӨ+ний даатгалын сангийн төлөвлөгөө 1730,09 сая төгрөг, гүйцэтгэл нь 1434,90 сая төгрөг байгаа бөгөөд 295,1 сая төгрөгийн хэмнэлттэй ажилласан. Мөн ажилгүйдлийн даатгалын сангийн төлөвлөгөө 10549,37 сая төгрөг, гүйцэтгэл нь 9297,43 сая төгрөг зарцуулсан бөгөөд 1251,93 сая төгрөгийн хэмнэлттэй гарсан. | |
| 2.1.10. | Батлагдсан зардлын төсөв, хөрөнгө оруулалтын зардлын үр ашгийг дээшлүүлж, хэмнэлтийн зарчмыг баримтлах. | | Батлагдсан төсвийг зардлын эдийн засгийн ангилал хооронд | Батлагдсан 1’947.75 сая төгрөгийн төсвийг зардлын ангиллын дагуу 1’894,20 сая төгрөгийг зарцуулсан. | а)Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх.<br>б)Батлагдсан төсвийг зардлын ангиллын дагуу зарцуулах | 2024 оны 06 дугаар сарын 11-ний байдлаар байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын А/03 дугаар “Үйл ажиллагааны урсгал зардлын 2024 оны төсвийн хуваарь батлах тухай | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | шилжүүлэн зарцуулахгүй, ажиллагсадтай холбоотой болон бусад өр авлагагүй ажиллана. | | в) Ажиллагсадтай холбоотой цалин, шимтгэл, татвар болон бусад өр авлага үүсгээгүй байна. | ”тушаалын дагуу бүлгийн дүнд багтаан эдийн засгийн ангиллаар нь зарцуулж нийт санхүүжилт 1,159.8 тэрбум төгрөгийн төсөв батлагдсанаас 06 дугаар сарын 11-ний байдлаар гүйцэтгэлээр цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардалд 876.9 сая төгрөг, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардалд 112.2 сая төгрөг ,байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 17.9 сая төгрөг, хангамж, бараа материалын зардалд 9.6 сая төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 7.2 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр болон бараа үйлчилгээний бусад зардал, харуул хамгаалалтын зардалд 9.4 сая төгрөг, ажил олгогчоос олгох тэтгэмж урамшууллын зардалд 4.1 сая төгрөг, зөвлөл, хороо комиссын гишүүдийн зардалд 70.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна. 2024 оны хагас жилийн байдлаар Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 03-р сарын 18-ны өдрийн А/34 дүгээр тушаал,2024 оны 04-р сарын 08-ны өдрийн А/47 дугаар тушаал, 2024 оны 05-р сарын 07-ны өдрийн А/67 дугаар тушаалуудаар | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | батлагдсан төсөвт 3 удаа өөрчлөлт хийгдсэн. Төсвийн хэмнэлтийн хууль, санхүүгийн тайлангийн аудитын зөвлөмжийн дагуу зардлыг хэмнэх, зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэн ажилласан. | |
| 2.1.11. | Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын сангийн болон байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөх, төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, санхүүгийн тайлан гаргах ажлыг зохион байгуулах | | Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайланг үнэн зөв гаргаж, тогтоосон хугацаанд хүргүүлнэ. | Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, байгууллагын төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээ, сангийн өр авлагын сарын мэдээг гаргаж, ирүүлсэн. | Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлийн тайлан, байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, байгууллагын төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээ, сангийн өр авлагын сарын мэдээг үнэн зөв гаргаж, хугацаанд нь хүргүүлсэн байна. | Төсвийн тухай хууль болон Нийгмийн даатгалын тухай хуулиудад нийцүүлэн урсгал зардлын төсвийн гүйцэтгэл,өр авлагын сарын мэдээг сар бүрийн эхний ажлын өдөр үнэн зөв гаргаж, хуулийн хугацаанд нь нийт 6 удаа Нийслэлийн нийгмийн даатгалын газарт хянуулж хүргүүлж баталгаажуулсан. Төсвийн гүйцэтгэлийн 1,2-р улирлын санхүүгийн тайланг хуулийн хугацаанд үнэн зөв гаргаж Нийслэийн нийгмийн даатгалын газарт хянуулан хүргүүлж баталгаажуулан ажилласан. | |
| | Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд | | Байгууллагын | Байгууллагын хэвийн үйл | -Үндсэн хөрөнгө актлах, | Тус газрын өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалтын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.12. | шаардагдах өмч хөрөнгийн хэрэгцээ, захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх, ил тод тайлагнах. | | хэвийн үйл ажиллагаанд шаардагдах өмч хөрөнгийн хэрэгцээ, захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөн хэрэгжүүлж, тайлагнаж ажиллана. | ажиллагаанд шаардагдах өмч хөрөнгийн хэрэгцээ, захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөн хэрэгжүүлж, тайлагнасан байна. | шилжүүлэх үйл ажиллагааг хууль дүрэм, журамд нийцүүлэн өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлт, холбогдох баримтыг үндэслэн хөрөнгийн нэмэгдэх, хасагдах хөдлөлийг цаг тухай бүрд нь бүртгэлд тусгах; -Эзэмшил газар, барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, үндсэн хөрөнгө г.м/ нэгдсэн судалгааны маягтууд ТӨХ /ТӨХ-1-с ТӨХ-11 маягт/ болон мэргэжлийн байгууллагад гаргаж өгдөг мэдээ тайланг хуулийн хугацаанд мэдээлэх; | байдалд өдөр тутам хяналт тавьж, бүртгэл хөтлөн, хагас жилийн эд хөрөнгийн тооллогыг 2021 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн “Журам батлах тухай” А/79 дугаар тушаалаар батлагдсан “Өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажиллах журам”-ыг үндэслэн БЗД-ийн Нийгмийн даатгалын газрын даргын “Өмч хөрөнгө, эд аж ахуйн тооллого хийх тухай” тушаалын дагуу 6-р сарын 5-7-ны өдөр үнэн зөв, чанартай хийж тооллогын үр дүнг байгууллагын ӨХБЗ-д танилцуулсан. 2024 оны хагас жилийн хөрөнгийн тооллогыг чанартай, үр дүнтэй хийхэд анхаарч тооллогын материалыг НДЕГ-ын хэлтэст тогтоосон хугацаанд хүргүүлсэн. Байгууллагын бүх үндсэн болон үндсэн бус хөрөнгийн ашиглалт, эзэмшилт, хадгалалтыг сайжруулах зорилгоор өмч хамгаалах байнгын комиссыг хуваарилан бүх хөрөнгийг биечлэн үзэж танилцаж тоолж бүртгэлийг сайжруулах тал дээр анхааран ажилласан. Албан хаагчдын ашиглаж байгаа эд хөрөнгийн картыг зурагжуулах, санхүүгийн программын өөрчлөлт | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | -Хагас болон бүтэн жилийн тооллогоор үнэ тогтоолгох, шилжүүлэх, актлах, хөрөнгийн жагсаалтыг тогтоосон хугацаанд хүргүүлэх;<br>-Хөрөнгийн ашиглалт хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж, үндсэн хөрөнгө, маягтын тооллого хийх ажлыг зохион байгуулж, дүнг хугацаанд нь хүргүүлэх;<br>-Өмч хамгаалах байнгын зөвлөл журмын дагуу ажиллуулах;<br>-Үндсэн хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийн тайланг “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем” | шинэчлэлтийг хийх ажлуудыг эхлүүлсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | програмд дараа оны 3 дугаар сарын 5-ны дотор оруулах;<br>-Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээ, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүрэн хангах, Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээний орлогыг санд бүрэн төвлөрүүлсэн байна. | | |
| 2.1.13. | Төсвийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж, Аудитын байгууллагаас “Өөрчлөлтгүй” дүгнэлттэй ажиллах. | | Өөрчлөлтгүй дүгнэлт авах, зөвлөмж, акт, албан шаардлагыг хугацаанд нь бүрэн биелүүлнэ. | а) Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлангийн Аудитын шалгалтаар хязгаарлалттай дүгнэлт авсан.<br>б) Санхүүгийн тайлангийн аудитын тайлангаар өгсөн залруулга, зөвлөмж, акт, албан шаардлагыг | а) Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлангийн Аудитын шалгалтаар “Өөрчлөлтгүй” дүгнэлт авах.<br>б) Санхүүгийн тайлангийн аудитын тайлангаар өгсөн залруулга, зөвлөмж, акт, албан шаардлагыг | Өмнөх онд Аудитын байгууллагаас “Өөрчлөлтгүй” дүгнэлт авч, 100 хувь ажилласан. Төсвийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж НББ-ийн тухай хууль болон дүрэм журмын дагуу бүртгэлийг хийж гүйцэтгэж байгаа бөгөөд Аудитын байгууллагаас “Өөрчлөлтгүй” дүгнэлт авахаар ажиллаж байна. Мөн өмнөх аудитын дүгнэлтээр ирүүлсэн албан шаардлагын биелэлтийг хангахаар ажил зохион байгуулан ажиллаж байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хэрэгжүүлсэн байна. | 100.0 хувь биелүүлсэн байна. | | |
| 2.1.14. | Нийгмийн даатгалын ерөнхий газраас банкуудтай байгуулсан ерөнхий гэрээг хэрэгжүүлэх, дүгнэх, биелэлтийг НДЕГ-т хүргүүлэх. | | Нийгмийн даатгалын ерөнхий газраас арилжааны банкуудтай байгуулсан "Хамтран ажиллах гэрээ"-г хэрэгжүүлэн, хэрэгжилтийг дүгнэн НДЕГ-т хүргүүлнэ. | Банкуудтай байгуулсан ерөнхий гэрээний хэрэгжилтийг хангаж ажилласан. Гэрээний хэрэгжилтийг дүгнэж, дүнг НДЕГ-т хүргүүлсэн байна. | а) Банкуудтай байгуулсан ерөнхий гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллах.<br>б) Гэрээний хэрэгжилтийг дүгнэж, дүнг НДЕГ-т хүргүүлсэн байна. | Нийгмийн даатгалын ерөнхий газраас арилжааны 6-н банктай байгуулсан "Хамтран ажиллах гэрээ"-г хэрэгжүүлэн өдөр тутмын орлого зарлагын гүйлгээг харилцагч банкаар дамжуулан хэвийн явуулж байна.<br>Өмнөх оны гэрээний биелэлтийг дүгнэн Нийгмийн даатгалын ерөнхий газарт 1 удаа хүргүүлэн ажилласан. | |
| 2.1.15. | Нийгмийн даатгалын сангийн цахим мэдээллийн санг тухай бүр үнэн зөв бүрдүүлэх. | | Холбогдох хууль тогтоомжийн дагуу мэдээллийг үнэн зөв оруулж бүртгэнэ. | Нийгмийн даатгалын сангийн мэдээллийн баазыг тогтоосон хугацаанд хаалт хийлгэсэн. | а) Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг цаг хугацаанд нь үнэн зөв бүртгэх ажлыг зохион байгуулж, бүртгэлийн алдаа, залруулга гаргахгүй байх.<br>б) Ажил олгогч, даатгуулагчийн мэдээллийг үнэн зөв бүртгэж | Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг цаг хугацаанд нь үнэн зөв бүртгэх ажлыг зохион байгуулж, бүртгэлийн алдаа, залруулга гаргахгүй 100 хувь ажилласан.<br>Ажил олгогч, даатгуулагчийн мэдээллийг үнэн зөв бүртгэж мэдээллийн сан 100 хувь бүрдүүлсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | мэдээллийн сан бүрдүүлсэн байна. | | |
| 2.1.16. | Нийгмийн даатгалын мэдээллийн систем хөгжүүлэх” төслийн хүрээнд Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн шинэчлэлтэй холбоотой ажлыг хэрэгжүүлэх. | | ХНХЯ-тай гэрээтэй Ай Ти Зон ХХК-ийн Төслийн багтай хамтран Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийг “Core” системээр хөтлөх ажлыг хийж гүйцэтгэнэ. | ХНХЯ-тай гэрээтэй Ай Ти Зон ХХК-ийн Төслийн багаас зохион байгуулсан ажлуудад оролцсон. | Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийг “Core” системээр хөтлөх ажлын гүйцэтгэлийг хангаж ажилласан байна. | НДЕГ болон Ай ти зон ХХК-иас зохион байгуулсан программтай холбоотой цаг үеийн сургалтуудад бүрэн хамрагдаж төвлөрсөн орлого бүртгэх таниулах, өглөг бүртгэх өглөг хаах зэрэг үйлдлийг бүрэн хийж байна. Мөн алдаатай буюу харилцагч таниагүй 500 гаруй хуулгыг бүрэн таниулж хагас жилийн санхүүгийн тайланг гаргах бэлтгэл ажлыг хийж байна. | |
| 2.1.17. | Нягтлан бодох бүртгэлийн тооцооны өглөг, авлагыг тооцоо нийлсэн актаар шинэчлэн баталгаажуулах | | Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулна. | Нийгмийн даатгалын байгууллагын санхүүгийн тайлангийн тооцооны үлдэгдлийг эзэн холбогдогч бүрээр бүрэн шинэчлэн баталгаажуулсан. | а) Нийгмийн даатгалын байгууллагын санхүүгийн тайлангийн тооцооны үлдэгдлийг эзэн холбогдогч бүрээр бүрэн шинэчлэн баталгаажуулах. б) Нийгмийн даатгалын сангийн | Нийгмийн даатгалын газрын Санхүү бүртгэлийн газраас ирүүлсэн чиглэлийн дагуу ААНБ тус бүрийн үлдэгдлийг тооцоо нийлэн үлдэгдлийг баталгаажуулан ажилласан. Тус газраас авсан судалгааг тухай бүр хийж явуулсан. Байгууллагын ажилчдын цалин хөлс, ээлжийн амралт, тэтгэмжийг анхан шатны баримтуудыг үндэслэн зохих журмын дагуу сар бүрийн 8-10, 23-25-нд тогтмол бодож тавьж | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | санхүүгийн тайлангийн тооцооны үлдэгдлийг эзэн холбогдогч бүрээр бүрэн шинэчлэн баталгаажуулсан байна. | олгож, цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардалд 1,034.7 тэрбум төгрөгийн төлөвлөгөөтэй /өссөн дүнгээр/, 1,034.7 тэрбум төгрөгийн гүйцэтгэл /өссөн дүнгээр/ гарч, нийт 12 удаа бодож тавьж олгосон байна. Төлөөлөгч, эрүүл мэндийн магадлалын салбар зөвлөлийн цалин урамшууллыг хурлын тэмдэглэл,цагийн тооцоо бусад анхан шатны баримтуудыг үндэслэн 6 удаа бодож тавьж олгосон. Мөн НДШ, ХХОАТ-ын тайланг гаргаж холбогдох сайтуудад байршуулан илгээсэн. | |
| 2.1.18 | ЭМД-ийн шимтгэлээ өөрөө хариуцан төлдөг даатгуулагчтай холбоотой өглөг авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж ЭМДЕГ-т хүргүүлэхтэй холбоотой холбогдох ажлуудыг хэрэгжүүлэх | | Эрүүл мэндийн даатгалын сангийн харилцах дансуудыг хаах, харилцах дансны үлдэгдэл болон тайлангаар гарсан авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар | Харилцах дансны үлдэгдэл болон санхүүгийн тайлангаар баталгаажуулсан авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулан ННДГ-тай тооцоо нийлэн хүлээлгэн өгсөн. | а) ЭМД-ын харилцах дансуудыг хаах, харилцах дансны үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.<br>б) Эрүүл мэндийн даатгалын авлага, өглөгийн тайлангийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулсан байна. 3903 | а) ЭМД-ын харилцах дансуудыг хааж, харилцах дансны үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулан НДЕГ-т хүргүүлсэн.<br>б) Эрүүл мэндийн даатгалын авлага, өглөгийн тайлангийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулсан байна. 3903 дансны үлдэгдлийг даатгуулагч тус бүрээр жагсаалт үйлдэж НДЕГ-т ирүүлсэн байна.<br>в) 3303 дансанд бүртгэлтэй ЭМД-ын ташаарсан орлогыг жагсаалт үйлдэж тооцоо нийлж баталгаажуулан НДЕГ-т хүргүүлэн ажилласан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | баталгаа жуулна. | | дансны үлдэгдлийг даатгуулагч тус бүрээр жагсаалт үйлдэж НДЕГ-т иргүүлсэн байна. в) 3303 дансанд бүртгэлтэй ЭМД-ын ташаарсан орлогыг жагсаалт үйлдэж тооцоо нийлж баталгаажуулан НДЕГ-т иргүүлнэ. | Хэрэгжилт 100 хувьтай. | |
| ***Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт*** | | | | | | | |
| Нийгмийн даатгалын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, сангийн болон үйл ажиллагааны зардлын зарцуулалтад аудит хийх, дүгнэлт зөвлөмж гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх | | | | | | | |
| 3.1.1. | Байгууллагын нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтэд хяналт тавих; | - | Нийтийн ил тод мэдээллийн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-8.6 дугаар заалтын дагуу 48 мэдээллийг веб сайт хуудсанд бүрэн, үнэн, зөв | Байгууллагын нээлттэй мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу 48 мэдээллийг 2023 оны байдлаар 59.5 хувьтай байршуулсан. | Байгууллагын нээлттэй мэдээллийг ил тод болгож, иргэдийн мэдээлэл хайх, хүлээж авах эрхийг бүрэн (100%) хангасан байна. | Нийгмийн даатгалын мэдээллийн ил тод, нээлттэй байдлын талаарх ажлын хүрээнд: Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны “Нээлттэй өгөгдөл байршуулах төлөвлөгөө, хуваарь батлах тухай А/20 дугаар тушаал”-аар өгөгдсөн чиглэлийн хүрээнд нээлттэй мэдээллийг цахим хуудсанд, байгууллагын мэдээллийн самбарт 100 хувь байршуулан ажиллаж байна.<br>Мөн дээрх ажлын хүрээнд 48 бүлэг 56 нэр төрлийн мэдээллийн төрийн мэдээллийн цахим системд бүртгэх ажлыг зохион | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | байршуулан ажлын тайланг ДАМГ-т 2024 оны 07 дугаар сарын 09, 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлнэ. | | | байгуулах ажлын хэсэг байгуулан төлөвлөгөөний дагуу байршуулан ажиллаж байна. | |
| 3.1.2. | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих; | - | Нийгмийн даатгалын байгууллагын сан, үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хагас жилийн байдлаар 85 мэдээллийг 07 дугаар сарын 09-ны өдрийн дотор, жилийн | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, 167 мэдээллийг 2023 оны байдлаар 95.7 хувьтай хугацаандаа мэдээлэл байршуулсан. | Нийгмийн даатгалын байгууллагын санхүү болон сангийн мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулж, иргэдийг үнэн, зөв мэдээллээр бүрэн (100%) хангасан байна. | Шилэн дансны тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд зааснаар нийгмийн даатгалын байгууллагын тухай бүр хэсэгт- 55, сар бүр хэсэгт- 24, жил бүр хэсэгт- 3, нийт 82 мэдээг гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт холбогдох журмын 2 дугаар хавсралтад заасан маягтын дагуу https://shilendans.gov.mn/ системд 100 хувь хуулийн хугацаанд байршуулан ажилласан.<br>Нийгмийн даатгалын байгууллагын санхүү болон сангийн мэдээллийг хуулийн хугацаанд 2024 оны хагас жилийн байдлаар 171 мэдээллийг бүрэн байршуулж, иргэдийг үнэн, зөв мэдээллээр | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | эцсийн байдлаар 167 мэдээллийг Shilendans.gov.mn цахим хуудсанд байршуулан ДАМГ-т 2024 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлнэ. | | | хангасан байхаас эхний хагас жилийн байдлаар 91 мэдээллийг оруулсан байна. | |
| Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг ажил олгогч, даатгуулагч, иргэн болон нийгмийн даатгалын орон нутгийн нэгжид хяналт шалгалт хийж шийдвэр гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, үр дүнг сайжруулах чиглэлээр санал боловсруулах | | | | | | | |
| 3.2.1. | Нийгмийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийг дээд газраас өгсөн чиглэлийн дагуу болон газрын даргын баталсан удирдамжийн дагуу аж ахуйн нэгж, байгууллага болон дотоодын хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах. | Шаард-лагагүй | Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг нийт аж ахуйн нэгж байгууллагын 20 хүртэл хувьд мөн нийгмийн | Илэрсэн төлбөр зөрчлийн 72,6 хувийг барагдуулж ажилласан. | Шалгалтын үр дүнг тухай бүрд нь тооцон, газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж холбогдох шийдвэр гаргуулж илэрсэн зөрчлийн 80-аас доошгүй хувийн барагдуулж | Баянзүрх дүүргийн нийгмийн даатгалын газрын даргын баталсан 01 тоот удирдамжийн хүрээнд: Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан хүлээн авах, хянах, баталгаажуулах, архивын нэгж болгосон байдалд хяналт, шалгалтын хийх ажлын хүрээнд Шалгалтыг 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрөөс 2024 оны 02 дугаар сарын 20-ний өдрийг дуустал хугацаанд | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | даатгалын 2-3 сангийн зарцуулалтад дотоодын хяналт шалгалт хийж илэрсэн төлбөр, зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулж ажиллана. | | ажилласан байна. | 2023 оны 01-12 саруудын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан /ЗНД-7, ЗНД-8/-г хүлээн авч, хянаж баталгаажуулсан байдлыг шалгалаа.<br>Мэдээллийн санд 14756 аж ахуй нэгж байгууллага бүртгэлтэй Үүнээс:<br>• Идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа - 8254<br>• Идэвхгүй-2255<br>• Зогссон болон татан буугдсан бүртгэлтэй - 3752<br>• Шилжиж явсан хөдөлгөөнтэй 495 ААНБ байна.<br>Шалгалтын явцад нийт 8254 ААНБ-ын тайланг цахим болон хэвлэмэл хэлбэрээр ирүүлсэн байдлыг шалгаж дүгнэлт, зөвлөмж өгч ажиллалаа.<br>Тухайлбал: Тус тасаг нь авлага барагдуулах ажлын хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулж ажилласан байна.<br>Үүнд:<br>1. Уулзалт зохион байгуулсан-1032,<br>2. Албан шаардлага хүргүүлсэн-1297,<br>3. Данс хаасан-3942,<br>4. Гэрээ байгуулсан-504 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 5. Шүүхэд шилжүүлсэн-53 г.м арга хэмжээ авч ажилласан байна.<br>Нийт давхардсан тоогоор 6828 ААНБ-д дээрх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн боловч өр авлага өмнөх оноос 7 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байгаа тухайн ажлыг эрчимжүүлэх, сайжруулах шаардлагатай байгааг дурдсугай.<br>Мөн хуримтлагдсан өртэй буюу 120 хоногоос дээш шимтгэлийн өртэй 2751 ААНБ-ын 44,7 тэрбум төгрөг, нийт авлагын 75 хувийг эзэлж байна.<br>Шимтгэл төлөлтийн тайлан баталгаажуулсан тайлангаас дараах зөрчил, дутагдал илэрлээ.<br>Тухайлбал:<br>✓ Шимтгэл төлөлтийн тайлан /ЗНД-7, ЗНД-8/ мэдээллийн сантай шимтгэлийн үлдэгдэл зөрүүтэй -30<br>✓ Ажил олгогч байгууллагын тамга, тэмдэг дарж баталгаажаагүй -27<br>✓ Байцаагчийн тамга тэмдэг дарагдаагүй-25<br>✓ Ажил олгогч байгууллагын удирдлагын гарын үсэг зурагдаагүй баталгаажаагүй-12 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ✓ Байцаагчийн гарын үсэг зурагдаагүй-20<br>✓ Шимтгэл төлөлтийн тайлан /НД-7, НД-8/-г тайланг цахимаар авч мэдээлэлд оруулсан боловч байгууллагын цаасан тайлан ирүүлээгүй -277<br>✓ Тоон гарын үсгээр тайлан илгээдэг ААНБ-1147<br>✓ Үйл ажиллагаа нь зогссон төлөвтэй ААНБ-г хөдөлгөөний төлөвийг засалгүйгээр тайланг татсан байх<br>✓ Ажил олгогч байгууллагын талаарх мэдээллийг /үндсэн мэдээлэл, утасны дугаар, хаяг байршил/ шинэчлэлт муу байна.<br>✓ ҮОМШӨ-ны даатгалыг 1,8-2,8 хувиар төлдөг ААНБ-ыг ердийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр буюу 550000 төгрөгөөр тайлан хүлээн авч баталгаажуулсан; /салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг баримтлаагүй/<br>Цахим хяналтын программын мэдээллээр давхардсан тоогоор Ажил олгогч байгууллагын даатгуулагчийн төрөл буруу -890, Ажил олгогч байгууллагад цалин өөрчилсөн мэдээлэл -3243, Ажил олгогч байгууллагад регистрийн дугаарын нэгтгэсэн -397 тоо | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | гарсан байдалд дүгнэлт, зөвлөмж өгч илэрсэн зөрчлийг арилгуулж ажиллалаа.<br>Удирдамж-2: Цахим хяналтын шалгалтын хүрээнд мэдээллийн сангийн шинэчлэлийн хүрээнд илэрсэн зөрчлийг тухай бүр хянаж шалгаж шийдвэрлэн ажиллаж байна.<br>Удирдамж-3 2023 онд шинээр тогтоосон тэтгэврийн тогтоолт олголтод хяналт шалгалт хийж ажлын хүрээнд-Тэтгэврийн мэдээллийн санд бүртгэлтэй нийт 3876 иргэний хувийн хэрэгт авагдсан материалд үндэслэн хяналт шалгалтыг 2024 оны 03 дугаар сарын 03-ны өдрөөс 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрүүдэд хийж гүйцэтгэсэн байна.<br>Шалгалтаар 14 тэтгэвэр авагчийн тэтгэвэр тогтоолт, зөрүүтэй тогтоогдсон зөрчил илэрч 10 иргэнтэй холбоотой 1,4 сая төгрөгийг төлүүлэх, 4 иргэнтэй холбоотой 1,7 сая төгрөгийн тэтгэврийг нөхөн олгох улсын байцаагчийн акт тогтоож мөн 103 тэтгэвэр авагчийн жагсаалтыг хүргүүлж зөрчлийг арилгуулж ажиллах талаар зөвлөмж өгч ажилласан байна;<br>Удирдамж-4 Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэрэгжилтийг “Хонгор кэй жи ХХК”-ны 2018-2023 оны санхүү, татварын тайланд хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ. Шалгалтаар тус байгууллага нь 2018-2023 оны нийт цалингийн сангаас ҮОМШӨ-ний даатгалын сангийн 1 хувийн зөрүүг дутуу тайлагнасан зөрчил илэрсэн тул улсын байцаагчийн актаар нөхөн төлүүлэхээр шийдвэрлэв.<br>Удирдамж-5 Нийгмийн даатгалын мэдээллийн санд бүртгэлтэй 2023 оны тэтгэврийн хувийн хэрэгт хяналтын тооллого хийх ажлын хүрээнд нийт 51215 тэтгэврийн хувийн хэргийг тооллогод хамруулж ажиллахад нийт 34 хувийн хэрэг дутсан ба түүнийг олж зөрчлийг арилгуулж ажиллах талаар үйлчилгээний тасагт зөвлөмж хүргүүлж ажилласан;<br>Удирдамж-6 Нийгмийн даатгалын сангаас 2023 онд олгосон нийт 51215 тэтгэврийн олголтыг шалгах ажлыг 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 01-ний хооронд зохион байгуулан ажиллаж байна.<br>Удирдамж-7 Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилтийг “Нью флат ворлд | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ХХК"-ны 2018-2023 оны санхүү, татварын тайланд хяналт шалгалтыг хийж гүйцэтгэж байна мөн газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн А/29 тоот тушаалын хүрээнд 2024 оны 01-05 дугаар саруудад зөрүүтэй болон жагсаалтаар олгогдсон тэтгэвэр, тэтгэмжийн олголтыг шалгах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. | |
| 3.2.2. | Хил хамгаалах ерөнхий газартай 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдөр байгуулсан 03/НД-22/23 дугаартай хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд зохион байгуулж хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг нэгтгэж дүгнэх, | Шаард-лагагүй | Хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлын үр дүнг хагас, бүтэн жилээр гаргаж 2024 оны 6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-ний өдрөөр тасалбар болгон ХШГ-т тайлагнах | Хил хамгаалах ерөнхий газартай хамтран ажиллах санамж бичгийг 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдөр шинэчлэн байгуулсан гэрээний дагуу | Холбогдох судалгаа, тооцоо, дүгнэлтэд үндэслэн Хилийн цэргийн анги, анги нэгтгэлээс гаргаж ирүүлсэн тайланг тухай бүр хүлээн авч хуулийн дагуу шийдвэрлэж ажиллах. | Нийгмийн даатгалын ерөнхий газар Хил хамгаалах ерөнхий газар, Зэвсэгт хүчний жанжин штаб хамтран ажиллах гэрээний дагуу хугацаат цэргийн албан хаагч болон цэргийн албан хаагчийн гэр бүлийн гишүүдийн шимтгэлийн нөхөн төлүүлэх тухай гэрээний дагуу хил хамгаалах ерөнхий газрын харьяа ХЦ-ийн 0164 ангийн 11 албан хаагчтай холбоотой шимтгэл төлөлтийг залруулах, ЗХЖШ-ын хамтран ажиллах гэрээний дагуу хугацаат цэргийн албан хаагчийн 1444 даатгуулагчийн тайлан хүлээн авч, регистрийн дугаар зөрүүтэй 400 иргэний регистрийн дугаарын олж тодруулах ажлыг тус тус хэрэгжүүлэн ажиллаж байна. | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | , Илэрсэн зөрчил, дутагдлын 70-аас доошгүй хувийг барагдуулсан байх | | | | |
| 3.2.3. | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн 2021-2023 оны орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт шалгалт хийх | | ҮОМШӨ-ний даатгалын сангийн зарцуулалтад шалгалт хийж илэрсэн зөрчилд хуулийн дагуу хариуцлага тооцож, үр дүнг эхний хагас жилээр тайлагнаж илэрсэн зөрчлийн 80 хүртэл хувийг барагдуулж ажиллах | - | ҮОМШӨ-ний сангийн бүрдүүлэлт, зарцуулалтыг мэдээллийн нэгдсэн сангийн өгөгдөл болон анхан шатны баримтад тулгуурлан шалгаж , шийдвэрлэх илэрсэн зөрчлийг бүрэн барагдуулж ажилласан байна. | Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5-3 дугаар зүйлийн 5-3-1, 5-3-2, Засгийн газрын 2023 оны 420 дугаар тогтоолоор баталсан “Салбарын хяналт шалгалтын 2024 оны төлөвлөгөө”-нд тус тус заасны дагуу Нийгмийн даатгалын байгууллагын Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн 2021-2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүнд Төрийн хяналт шалгалтын тухай, “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг санхүүжүүлэх журам” болон бусад холбогдох дүрэм, журамд нийцүүлэн Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2024 оны 02-р сарын 07 ны өдрийн 13-07/08 тоот Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай удирдамжинд дурьдсан асуудлын хүрээнд 2024 оны 02 | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сарын 27-ноос 04 сарын 29 ны хооронд Баянзүрх, Чингэлтэй, Баянгол, Сүхбаатар Сонгинохайрхан дүүргийн Нийгмийн даатгалын газарт Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүнд 2021-2023 оны санхүүгийн болон холбогдох бусад баримт материалыг хамруулж Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, тэтгэвэр тэтгэмжийн тогтоолт, олголт, тэтгэврийн хувийн хэргийг тэтгэврийн массивтай тулгах, 2021-2023 онд шинээр тогтоосон тэтгэврийн бодолт, олголтын байдлыг тулган шалгаж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, хуульд заасан арга хэмжээг авч, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор зөрчлийг дахин гаргуулахгүй байх талаар бодит байдалд дүгнэлт хийж ажиллалаа.<br>Шалгалтаар нийт 12 .заалт бүхий улсын байцаагчийн 4 актыг БЗД, БГД, СБД, СХД-ийн НДГ, ХХҮХ-үүдэд өгч ажиллаж байна. | |
| | Нийгмийн хамгааллын салбарын хяналтын | | Хяналт шалгалт | | Их, дунд эрсдэл бүхий аж ахуйн | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны салбарын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.2.4. | чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн объектод төлөвлөгөөт шалгалт хийх | | хийсэн объектын тоогоор , гүйцэтгэлийн хувь, хууль сахин мөрдөлтийн түвшин, илрүүлсэн зөрчил, арилгуулах ажлын хувь, улсын байцаагчийн шийдвэрийн биелэлт, эрсдэлийн түвшин буурсан объектын тоо, хувь | | нэгж байгууллагын 80-аас доошгүй хувийг шалгаж, илэрсэн зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулж ажилласан байна. | хяналтын газрын дарга бөгөөд салбарын улсын ерөнхий байцаагчийн 2024 оны 02 дугаар сарын 07 өдрийн 13-07/10 тоот “Барилга угсралт болон барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудад төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай” хяналт шалгалтын удирдамжийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн “Хяналт шалгалт хийх төлөвлгөө батлах тухай “420 дугаар тогтоолыг үндэслэн аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт барилга угсралт болон барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа 15-н аж ахуйн нэгж байгууллагуудад Төрийн хяналт шалгалтын тухай, Хөдөлмөрийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай, Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай, Ахмад настны тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай, Нийгмийн даатгалын ерөнхий хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандарт, | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нйитлэг журам”-ын хэрэгжилтэд төлөвлөгөөт хяналт шалгалт хийж холбогдох хяналтын хуудсаар эрсдлийн болон хууль сахин мөрдөлтийн түвшинг тогтоож, болзошгүй осол гэмтэл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч, Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч нартай хамтарч хяналт шалгалтыг 2024 оны 06 дугаар сарын 03-наас 2024 оны 10 дугаар сарын 01-ны дотор хийж гүйцэтгэхээр хяналт шалгалтын удирдамж, хяналтын хуудсыг аж ахуйн нэгжүүдэд танилцуулан ажиллаж байна.<br>Барилгын салбарын хяналт шалгалтад Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт барилга угсралт болон барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 15 аж ахуйн нэгж байгууллагуудыг хамруулахаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.1 | Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/ болон Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан дүрэм, журам, дээд газраас ирүүлсэн заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг зохион байгуулах; | | Хэрэгжүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн тоо | Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой НДЕГ-аас 2024 онд ирүүлсэн 15 чиглэл, 14 зөвлөмжийг 100 хувь хэрэгжүүлэн зохион байгуулан ажилласан. | Дээд газраас ирүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж, үр дүнг тооцож ажилласан байна. | Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр 2025 оны эхний хагас жилийн байдлаар зөвлөмж-10, журам-1, тушаал-14, заавар-8, аргачлал-1, шийдвэр-1, чиглэл-11 нийт 46 заавар, чиглэл, зөвлөмжийг нэгжүүдэд танилцуулан хэрэгжилтийн тайлан, мэдээг гаргуулан, нэгтгэн дээд газарт хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна. | 100 хувь |
| 1.2. | Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий | | | | | НДЕГ-ын 2025 оны 01-р сарын 13-ны өдрийн №01/84 тоот ‘’2025 оны төсвийн хуваарь хүргүүлэх тухай’’ | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | газрын даргын баталсан нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлын төсвийн нарийвчилсан хуваарь, сар, улирлын хуваарийг мөрдөж ажиллах; | | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаалаар баталсан хуваарийн дагуу төсвийг зарцуулсан байна. | Нийгмийн даатгалын байгууллагын 2024 оны үйл ажиллагааны урсгал зардалд 2’715,87 сая төгрөг зарцуулсан. | Батлагдсан төсвийн хуваарь, дээд газраас ирүүлсэн зөвлөмж, чиглэлийг мөрдөж ажилласан байна. | албан бичиг, НДЕГ-ын даргын 2025 оны 01-р сарын 06-ны өдрийн №А/02 дугаар ’’Үйл ажиллагааны урсгал зардлын 2025 оны төсвийн хуваарь батлах тухай’’ тушаалаар батлагдсан 2025 оны батлагдсан төсөвтэй танилцан байгууллагын хэвийн үйл ажиллагааг ханган ажиллах зорилгоор бүлгийн дүнд багтаан эдийн засгийн ангиллаар нь зарцуулан ажилласан. 2025 оны эхэнд 3,411,800 сая төгрөгийн батлагдсан төсөвтэй байсан ба батлагдсан төсөв хүрэлцэхгүй болон зардал хооронд шилжүүлэх саналыг холбогдох тооцоо, судалгаа, тайлбарын хамт НДЕГ-т 2025 оны 3-р сарын 20, 4-р сарын 16, 5-р сарын 24, 6-р сарын 4-ний өдөр 4 удаа хүргүүлсэн. Батлагдсан төсвийн санхүүжилт 1,245,600 сая төгрөг 100% хийгдсэн. Үүнээс 1,148,800 сая төгрөг буюу 92,2% хувийн зардлын гүйцэтгэлтэйгээр Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.3. | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажлын биелэлтийг хангах; | 15 сая | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний тоогоор | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулах төсөв суугдаагүй тул арга хэмжээ зохион байгуулагдаагүй.. | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангасан байна. | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулах төсөв суугдахаар арга хэмжээ зохион байгуулан хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. | 100 хувь |
| 1.4. | Ажил олгогч, иргэд, даатгуулагчаас сэтгэл ханамжийн судалгаа авах ажлыг зохион байгуулж, үр дүнг хагас жил тутам Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлэх; | | 2 удаагийн сэтгэл ханамжийн судалгаа хийгдсэн байна. | - | Ажил олгогч, иргэд, даатгуулагчийн сэтгэл ханамжийг 1-5 оноогоор дүгнэж, судалгааны үр дүнг албан бичгээр 6 дугаар сарын 10, 12 сарын 10-ны өдрийн дотор Нийгмийн даатгалын ерөнхий газар хүргүүлсэн байна. | Нийгмийн даатгалын үйлчилгээг тэгш, хүртээмжтэй хүргэх, үйлчилгээний чанарт үнэлэлт, дүгнэлт өгөх зорилгоор тайлант оны эхний хагас жилд хоёр удаагийн сэтгэл ханамжийн судалгааг авч ажилласан байна.<br>Тус судалгааны үр дүнгээр 2025 оны 1, 2 дугаар улиралд иргэд, даатгуулагчдаас нийгмийн даатгалын үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар 10 асуултаас бүрдэх сэтгэл ханамжийн судалгааг авч, нэгтгэн дүгнэлээ. | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Эхний хагас жилд 360 даатгуулагчаас сэтгэл ханамжийн судалгааг авч үр дүнг нэгтгэж ажилсан. Судалгаанд хамрагдсан оролцогчдын цахимаар 230 цаасаар 130 хүн хамрагдаж судалгааны үр дүнд олон нийт үйлчилгээний чанарт хангалттай сайн үнэлгээ өгсөн 52% сайн үнэлгээг 36% Бүрэн гүйцэд авч чадаагүй 16% гэж өгсөн бөгөөд цаашид: Үйлчилгээний чанарыг сайжруулах, Цахим үйлчилгээний талаарх мэдээллийг түгээх ажлыг эрчимжүүлэх, Иргэдийн дунд хууль тогтоомжийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, тал дээр анхаарч ажиллах шаардлагатай гэсэн санал, хүсэлтүүд гарсан тул эдгээрийг тусган Үйлчилгээний чанарыг сайжруулах, цахим системийг илүү ойлгомжтой байлгах, Иргэдийн мэдлэгийг нэмэгдүүлэх сар бүрийн цахим сургалт тогтмол зохион байгуулах шаардлагатай нь тодорхойлогдож байна . | |
| ***Хоёр. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт*** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| ***Зорилт 2:*** *“Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлын санхүүжилт, шимтгэлийн хөнгөлөлт,чөлөөлөлтийг хуулиар тогтоосон хугацаанд олгох, өр барагдуулах ажлыг удирдан зохион байгуулах, өмчийн харилцаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, мөнгөжүүлсэн орлогыг тэтгэврийн нөөц санд байршуулах, нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулж, сангийн хөрөнгийг нэмэгдүүлэх, нягтлан бодох бүртгэлийн мэргэжил арга зүйгээр хангах, гүйцэтгэлийг тайлагнах”* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 2.1. | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны А/183 тоот тушаалаар батлагдсан “Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх, хуваарилах, санхүүжилт олгох, хяналт тавих журам”-ын 3.3 дах заалтыг хэрэгжүүлж ажиллах. | | НДЕГ-ын төвлөрсөн орлогын харилцах дансанд өдөр бүр бүрэн төвлөрүүлнэ. | Нийгмийн даатгалын төвлөрсөн сангийн харилцах дансны орлого 484781.05 сая төгрөгийг өдөр бүр төвлөрүүлсэн. | НДЕГ-ын төвлөрсөн орлогын харилцах дансанд өдөр бүр бүрэн төвлөрүүлсэн байна. | Нийгмийн даатгалын ерөнхий газрын Санхүү бүртгэл, хөрөнгө оруулалтын газрын даргын 2023.12.27-ны өдрийн тушаалаар 2024 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн нийгмийн даатгалын сангийн төвлөрсөн орлогын дансны үлдэгдлийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын төвлөрсөн орлогын харилцах дансанд өдөр бүр төвлөрүүлнэ гэсний дагуу 5 сарын 31-ний байдлаар нийт 197◌◌'26,05 сая төгрөг төвлөрүүлэн ажилласан. | 100 хувь |
| 2.2. | Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулах. | | Хууль тогтоомжийн дагуу иргэд даатгуулагчдад тэтгэвэр тэтгэмж төлбөр зардлыг хугацаанд нь олгоно. | Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулсан. | а) Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төсвийн дагуу хуульд заасан хугацаанд зарцуулсан байна.<br>б) Төсвийн хуваарьт оруулах саналаа тухай бүр НДЕГ-т хүргүүлсэн байна. | Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төлөвлөгөө болон орж ирсэн санхүүжилтийн дагуу зарцуулж байгаа бөгөөд эхний 6 сарын гүйцэтгэлээр тэтгэврийн сангийн төлөвлөгөө 288923,34 сая төгрөг, хүлээгдэж буй гүйцэтгэл 291487,56 сая төгрөг буюу 2564,22 сая төгрөгийн хэтрэлттэй байна. Тэтгэмжийн даатгалын сангийн төлөвлөгөө 18’893,21 сая төгрөг, хүлээгдэж буй | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | в) Нийгмийн даатгалын сан хариуцах шимтгэлийг гүйцэтгэлээр бүрэн шилжүүлсэн байна. | гүйцэтгэл нь 17◌◌'713,40 сая төгрөг байх бөгөөд 1179,81 сая төгрөгийн хэмнэлттэй байна. ҮОМШӨ+ний даатгалын сангийн төлөвлөгөө 2366,92 сая төгрөг, хүлээгдэж буй гүйцэтгэл нь 2111,64 сая төгрөг байгаа бөгөөд 255,28 сая төгрөгийн хэмнэлттэй ажилласан. Мөн ажилгүйдлийн даатгалын сангийн төлөвлөгөө 14302,8 сая төгрөг, хүлээгдэж буй гүйцэтгэл нь 14523,59 сая төгрөг зарцуулсан бөгөөд 220,79 сая төгрөгийн хэтрэлттэй байна. | |
| 2.3. | Батлагдсан зардлын төсөв, хөрөнгө оруулалтын зардлын үр ашгийг дээшлүүлж, хэмнэлтийн зарчмыг баримтлах. | | Батлагдсан төсвийг зардлын эдийн засгийн ангилал хооронд шилжүүлэн зарцуулахгүй, ажиллагсадтай холбоотой болон бусад өр авлагагүй | Батлагдсан 2’889.66 сая төгрөгийн төсвийг зардлын ангиллын дагуу 2’715,87 сая төгрөгийг зарцуулсан. | а)Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх.<br>б)Батлагдсан төсвийг зардлын ангиллын дагуу зарцуулах<br>в) Ажиллагсадтай холбоотой цалин, шимтгэл, татвар болон бусад өр авлага үүсгээгүй байна. | 2025 оны 05 дугаар сарын 31-ний байдлаар байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын А/03 дугаар “Үйл ажиллагааны урсгал зардлын 2025 оны төсвийн хуваарь батлах тухай ”тушаалын дагуу бүлгийн дүнд багтаан эдийн засгийн ангиллаар нь зарцуулж нийт санхүүжилт 1,245,600 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 05 дугаар сарын 31-ний байдлаар гүйцэтгэлээр нийт-1,148,800 сая төгрөг, үүнээс; цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардалд 956.3 | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | ажиллана. | | | сая төгрөг, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардалд 119.5 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 19.5 сая төгрөг, хангамж, бараа материалын зардалд 7.8 сая төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 1.3 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр болон бараа үйлчилгээний бусад зардал, харуул хамгаалалтын зардал, өмгөөлөл хуулийн зөвлөхийн зардалд 3.6 сая төгрөг, ажил олгогчоос олгох тэтгэмж урамшууллын зардалд 3.0 сая төгрөг, зөвлөл, хороо комиссын гишүүдийн зардалд 40.5 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна. 2025 оны 5-р сарын 31-ний байдлаар төсөв нэмэгдүүлэх болон зардал хооронд шилжүүлэх саналын дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 03-р сарын 11-ний өдрийн А/49 дүгээр тушаал, 2025 оны 05-р сарын 06-ны өдрийн А/129 дүгээр тушаалуудаар батлагдсан төсөвт нийт 2 удаа өөрчлөлт хийгдсэн. Төсвийн хэмнэлтийн хуулийн дагуу зардлыг 7,8%-иар хэмнэж, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэн ажилласан. | |
| 2.4. | Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын сангийн болон байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөх, төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, санхүүгийн тайлан гаргах ажлыг зохион байгуулах | | Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайланг үнэн зөв гаргаж, тогтоосон хугацаанд хүргүүлнэ. | Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, байгууллагын төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээ, сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг гаргаж, ирүүлсэн. | Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлийн тайлан, байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, байгууллагын төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээ, сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг үнэн зөв гаргаж, хугацаанд нь хүргүүлсэн байна. | Төсвийн тухай хууль болон Нийгмийн даатгалын тухай хуулиудад нийцүүлэн урсгал зардлын төсвийн гүйцэтгэл,өр авлагын сарын мэдээг сар бүрийн эхний ажлын өдөр үнэн зөв гаргаж, хуулийн хугацаанд нь нийт 6 удаа Нийгмийн даатгалын ерөнхий газарт хянуулж хүргүүлж баталгаажуулсан. Төсвийн гүйцэтгэлийн 1, 2-р улирлын санхүүгийн тайланг хуулийн хугацаанд үнэн зөв гаргаж НДЕГ-т хянуулан хүргүүлж баталгаажуулан ажилласан. | 100 хувь |
| 2.5. | Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах өмч хөрөнгийн хэрэгцээ, захиран зарцуулалт, | | Байгууллагын хэвийн үйл ажиллага | Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах өмч хөрөнгийн | -Үндсэн хөрөнгө актлах, шилжүүлэх үйл ажиллагааг хууль дүрэм, | Байгууллагын өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалтын байдалд өдөр тутам хяналт тавьж, анхан шатны болон Нягтлан бодох бүртгэл | *100 хувь* |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хадгалалт хамгаалалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх, ил тод тайлагнах. | | анд шаардагдах өмч хөрөнгийг захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөн хэрэгжүүлж, тайлагнаж ажиллана. | хэрэгцээ, захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөн хэрэгжүүлж, тайлагнасан байна. | журамд нийцүүлэн өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлт, холбогдох баримтыг үндэслэн хөрөнгийн нэмэгдэх, хасагдах хөдлөлийг цаг тухай бүрд нь бүртгэлд тусгах;<br>-Эзэмшил газар, барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, үндсэн хөрөнгө г.м/ нэгдсэн судалгааны маягтууд ТӨХ /ТӨХ-1-с ТӨХ-11 маягт/ болон мэргэжлийн байгууллагад гаргаж өгдөг мэдээ тайланг хуулийн хугацаанд мэдээлэх;<br>-Хагас болон бүтэн жилийн тооллогоор үнэ тогтоолгох, | хөтлөн, 2025 оны хагас жилийн эд хөрөнгийн тооллогыг 2022 оны 65 дугаар тогтоолоор баталсан “Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг мөрдөж БЗД-ийн Нийгмийн даатгалын газрын даргын “Өмч хөрөнгө, эд аж ахуйн тооллого хийх тухай” тушаалын дагуу 6-р сарын 5-7-ны өдөр үнэн зөв, чанартай хийж тоологын үр дүнг холбогдох байгууллагад тайлагнаж ажилласан. хагас жилийн хөрөнгийн тооллогыг чанартай, үр дүнтэй хийхэд анхаарч тооллогын материалыг НДЕГ-ын СБХОГазарт тогтоосон хугацаанд хүргүүлсэн.Байгууллагын бүх үндсэн болон үндсэн бус хөрөнгийн ашиглалт, эзэмшилт, хадгалалтыг сайжруулах зорилгоор өмч хамгаалах байнгын зөвлөлийн гишүүдэд ажлыг хуваарилан бүх хөрөнгийг биечлэн үзэж танилцаж тоолж бүртгэлийг сайжруулах тал дээр анхааран ажилласан. 2025 оны 4-р сарын 03-ны өдрийн ‘’Үндсэн хөрөнгө шилжүүлэх, актлах, ашиглалтын хугацааг сунгаж, үнийг шинэчлэх жагсаалт’’ | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | шилжүүлэх, актлах, хөрөнгийн жагсаалтыг тогтоосон хугацаанд хүргүүлэх;<br>-Хөрөнгийн ашиглалт хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж, үндсэн хөрөнгө, маягтын тооллого хийх ажлыг зохион байгуулж, дүнг хугацаанд нь хүргүүлэх;<br>-Өмч хамгаалах байнгын зөвлөл журмын дагуу ажиллуулах;<br>-Үндсэн хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийн тайланг “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем” программд дараа оны 3 дугаар сарын 5- | ирүүлэх тухай 01/767 тоот албан бичгээр байгууллагын хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглалтын хугацаа сунгах, цаашид ашиглах боломжгүй болсон үндсэн хөрөнгийг актлах 16 хуудас бүхий саналыг хүргүүлсэн. Байгууллагын газрын 000437367 дугаартай гэрчилгээний хугацаа 2019 онд дууссан тул Ланд Овнер ХХК-тай гэрээ байгуулан 382м2 талбайд Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгаа хийлгэн дүгнэлтийг гаргуулан Нийслэлийн газар зохион байгуулалтын албанд холбогдох материалуудыг бүрдүүлэн өгч ‘’иргэн, хуулийн этгээдэд газар эзэмшүүлэх гэрээ’’ №01110-2025/00310-аар<br>гэрчилгээний хугацааг шинэчилж №0000348931 дугаар бүхий шинэ гэрчилгээг авсан.ТӨБЗГ-ын даргын 2024 оны 3-р сарын 21-ний өдрийн 139 дүгээр тогтоолын дагуу БЗД-ийн 23-р хорооны нутаг дэвсгэрт байрлах ‘’Алтан орлогын гол’’ ХХК-ийн эзэмшлийн ‘’Эрхэт’’ худалдааны төвийн байранд 30,29 м.кв талбайг түрээслэх | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ны дотор оруулах;<br>-Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээ, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүрэн хангах, Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээний орлогыг санд бүрэн төвлөрүүлсэн байна. | зөвшөөрөл хүссэн 01/56 тоот албан бичгийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт 2025 оны 02-р сарын 24-ний өдөр хүргүүлж Зөвшөөрсөн хариуг хүлээн авсан. | |
| 2.6. | Төсвийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж, Аудитын байгууллагаас “Өөрчлөлтгүй” дүгнэлттэй ажиллах. | | Өөрчлөлтгүй дүгнэлт авах, зөвлөмж, акт, албан шаардлагыг хугацаанд нь бүрэн биелүүлнэ. | а) Нийгмийн даатгалын байгууллагын болон сангийн санхүүгийн тайлангийн Аудитын шалгалтаар өөрчлөлтгүй дүгнэлт авсан.<br>б) Санхүүгийн тайлангийн аудитын тайлангаар өгсөн залруулга, зөвлөмж, акт, албан шаардлагыг | а) Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлангийн Аудитын шалгалтаар “Өөрчлөлтгүй” дүгнэлт авах.<br>б) Санхүүгийн тайлангийн аудитын тайлангаар өгсөн залруулга, зөвлөмж, акт, албан шаардлагыг 100.0 хувь | Төсвийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж НББ-ийн тухай хууль болон дүрэм журмын дагуу бүртгэлийг хийж гүйцэтгэж байгаа бөгөөд 2024 оны үйл ажиллагаа, сангийн санхүүгийн тайланд Аудитын байгууллагаас “Өөрчлөлтгүй” дүгнэлт авч ажилласан. Мөн өмнөх аудитын дүгнэлтээр ирүүлсэн албан шаардлагын биелэлтийг хангахаар ажил зохион байгуулан ажиллаж байна. | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хэрэгжүүлсэн байна. | биелүүлсэн байна. | | |
| 2.7. | Банкуудтай байгуулсан ерөнхий гэрээг хэрэгжүүлэх, дүгнэх, биелэлтийг Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлэх. | | Нийгмийн даатгалын ерөнхий газраас арилжааны банкуудтай байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-г хэрэгжүүлэн, хэрэгжилтийг дүгнэн Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлнэ. | Арилжааны 5 банкуудтай байгуулсан ерөнхий гэрээний хэрэгжилтийг хангаж ажилласан. | а) Банкуудтай байгуулсан ерөнхий гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллах.<br>б) Гэрээний хэрэгжилтийг дүгнэж, дүнг Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлсэн байна. | Нийгмийн даатгалын ерөнхий газраас арилжааны банкуудтай байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-г хэрэгжүүлэн өдөр тутмын орлого зарлагын гүйлгээг харилцагч банкаар дамжуулан хэвийн явуулж байна. Өмнөх оны гэрээний биелэлтийг дүгнэн НДЕГ-т хүргүүлэн ажилласан. | 100 хувь |
| 2.8. | Нийгмийн даатгалын сангийн цахим мэдээллийн санг тухай бүр үнэн зөв бүрдүүлэх. | | Холбогдох хууль тогтоомжийн дагуу мэдээллийг үнэн зөв оруулж бүртгэнэ. | Нийгмийн даатгалын сангийн мэдээллийн баазыг тогтоосон хугацаанд хаалт хийлгэсэн. | а) Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг цаг хугацаанд нь үнэн зөв бүртгэх ажлыг зохион байгуулж, бүртгэлийн алдаа, залруулга гаргахгүй байх. | Ажил олгогч, даатгуулагчийн мэдээллийг үнэн зөв бүртгэж, 2024 оны жилийн эцсийн мэдээллийн баазыг тогтоосон хугацаанд хаалт хийлгэсэн.<br>Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг цаг хугацаанд нь үнэн зөв бүртгэх ажлыг зохион байгуулж, | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | б) Ажил олгогч, даатгуулагчийн мэдээллийг үнэн зөв бүртгэж мэдээллийн сан бүрдүүлсэн байна. | бүртгэлийн алдаа, залруулга гаргахгүй ажилласан.<br>Ажил олгогч, даатгуулагчийн мэдээллийг үнэн зөв бүртгэж мэдээллийн сан бүрдүүлсэн.<br>Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн дагуу:<br>1. Өндөр насны тэтгэвэр 1039, хөдөлмөрийн чадвар алдсны 328 , тэжээгч алдсны 85, цэргийн албан хаагчийн тэтгэвэр 39 буюу нийт 1491 тэтгэвэр тогтоож олгосон байна. Мөн 2024 оноос хэрэгжиж байгаа тэтгэврийн тусгай зохицуулалтыг 105 тэтгэвэр авагчдад олгож байна.<br>2. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн дагуу<br>Үүнд:<br>Жирэмсэн амаржсаны 1452 тэтгэмж, Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэмж 2701.<br>3. Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлын тэтгэмж 1158 даатгуулагчид тогтоож олгосон байна. Мөн рашаан сувилалын зардал 7 даатгуулагчид, Нас барсан иргэний ар гэрт олгох тэтгэмж 351 тэтгэвэр авагч болон даатгуулагчид олгон ажиласан байна. Сикост | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | системд нийт 7265 даатгуулагчийн мэдээлэлийг үнэн зөв бүрдүүлэн хуулийн хугацаанд нь тэтгэвэр, тэтгэмжийг олгосон байна. | |
| 2.9. | Нийгмийн даатгалын мэдээллийн систем хөгжүүлэх” төслийн хүрээнд Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн шинэчлэлтэй холбоотой ажлыг хэрэгжүүлэх. | | ХНХЯ-тай гэрээтэй Ай Ти Зон ХХК-ийн Төслийн багтай хамтран Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийг “Core” системээр хөтлөх ажлыг хийж гүйцэтгэнэ. | ХНХЯ-тай гэрээтэй Ай Ти Зон ХХК-ийн Төслийн багаас зохион байгуулсан ажлуудад оролцсон. | Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийг “Core” системээр хөтлөх ажлын гүйцэтгэлийг хангаж ажилласан байна. | НДЕГ болон Ай ти зон ХХК-иас зохион байгуулсан программтай холбоотой цаг үеийн сургалтуудад бүрэн хамрагдаж төвлөрсөн орлого бүртгэх таниулах, өглөг бүртгэх өглөг хаах зэрэг үйлдлийг бүрэн хийж байна. Мөн алдаатай буюу харилцагч таниагүй 600 гаруй хуулгыг бүрэн таниулж хагас жилийн санхүүгийн тайланг гаргах бэлтгэл ажлыг хийж байна. | 100 хувь |
| 2.10. | Нягтлан бодох бүртгэлийн тооцооны өглөг, авлагыг тооцоо нийлсэн актаар шинэчлэн баталгаажуулах | | Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулна. | Тооцооны үлдэгдлийг баталгаажуулсан. | а) Нийгмийн даатгалын байгууллагын санхүүгийн тайлангийн тооцооны үлдэгдлийг эзэн холбогдогч бүрээр бүрэн шинэчлэн баталгаажуулах. | Нийгмийн даатгалын газрын Санхүү бүртгэлийн газраас ирүүлсэн чиглэлийн дагуу ААНБ тус бүрийн үлдэгдлийг тооцоо нийлэн үлдэгдлийг баталгаажуулан ажилласан. Тус газраас авсан судалгааг тухай бүр хийж явуулсан. Батлагдсан төсөв хүрэхгүйгээс болж НДШ, ХХОАТатварын өглөг үүсэж байгаа тухай бүр буюу 4 удаа | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | б) Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлангийн тооцооны үлдэгдлийг эзэн холбогдогч бүрээр бүрэн шинэчлэн баталгаажуулсан байна. | албан бичгийг холбогдох баримтын хамт НДЕГ-т хүргүүлсэн байгаа болно. | |
| ***Зорилт 2.1:*** *“Нийгмийн даатгалын хууль тогтоомжид заасны дагуу шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх, сан бүрдүүлэх, ажил олгогч, даатгуулагч, сайн дураар даатгуулагчдыг нимгийн даатгалд хамруулах, шимтгэлийн өр барагдуулах ажлыг зохион байгуулах ажлыг зохион байгуулах, аж ахуйн нэгж, байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, нийгмийн даатгалын байгууллагуудыг мэргэжил, арга зүгээр хангах”* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 2.1.1. | Сайн дурын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор малчид болон албан бус хөдөлмөр эрхлэгч иргэдийг сайн дурын даатгалд шинээр хамруулах төлөвлөгөө баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах; | | Сайн дурын даатгалд шинээр хамруулсан даатгуулагч (малчин)-ийн тоо, өсөлтийн хувь, төлөвлөгөөний биелэлтийн хувь | 2024 онд 18491 хүнийг сайн дурын даатгалд, үүнээс 87 малчин хамруулав. | Сайн дурын даатгалд шинээр 1511 хүнийг үүнээс 19 малчин шинээр хамруулж төлөвлөгөөг биелүүлсэн байна. | 2025 оны эхний хагас жилд сайн дурын даатгалд нийт 1888 даатгуулагч хамруулсан байна үүнээс 0-3 насны хүүхдээ асарч байгаа ээж 139, Малчин 20, ХБИ 101 гэрээ байгуулж ажилласан байна. | 100 хувь |
| 2.1.2. | Албан журмын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор нийгмийн даатгалд | | Албан журмын даатгалд шинээр | 2024 онд 8593 ажил олгогч, 140483 хүнийг албан журмын | Ажил олгогчийн тоог шинээр 198, даатгуулагчийн тоог шинээр | 2025 оны эхний хагас жилд 228 ажил олгогч шинээр хамруулан тайлан хүлээн авч ажиллаж байна. Мөн 5324 | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хамрагдаагүй ажил олгогч, даатгуулагчдыг шинээр хамруулах төлөвлөгөө баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах; | | хамрагдсан ажил олгогч, албан журмын даатгуулагчийн тоо, өсөлтийн хувь, төлөвлөгөөний биелэлтийн хувь | даатгалд хамруулав. | 4825 хүнээр нэмэгдүүлж, төлөвлөгөөг биелүүлсэн байна. | хүнийг шинээр албан журмын даатгалд хамруулан ажилласан байна. | |
| 2.1.3. | Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн авлагыг оны эхний үлдэгдэлээс 20 доошгүй хувиар бууруулах; | | Хуримтлагдсан авлагыг тухайн санхүүгийн жилд бүрэн барагдуулсан байх | Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын хэмжээ 2024 оны жилийн эцэст 77422,60 сая төгрөгт хүрсэн. | Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын хэмжээ 23226,78 сая төгрөгийг /2.1.4-д зааснаас бусад шимтгэлийн авлага/ бүрэн барагдуулах.<br>Шинээр нэмж өр үүсгэхгүй байх талаар анхаарч ажиллах. | Хуримтлагдсан авлага барагдуулах 120 хоногийн аянг зарлан, байгууллагын өр, авлагын хэмжээ насжилтыг тодорхойлсон судалгааг гарган, тайлан шимтгэлийн авлага барагдуулах журмын дагуу арга хэмжээг шат дараалан авч, гадуур ажиллах хуваарь гарган өртэй ажил олгогчтой уулзалт хийн ажиллаж байна. 11029,64 сая төгрөгийн өртэй 188 ажил олгогчид улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлж, 47345,07 сая төгрөгийн өртэй 2112 ажил олгогчийн арилжааны банкин дах харилцах дансны зарлагын гүйлгээг хааж, 11886,32 сая төгрөгийн өртэй 107 ажил олгогчтой авлага барагдуулах гэрээг байгуулан | 100 хувь |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажилласан. Нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг төлүүлэхээр нийт 67 аж ахуйн нэгж байгууллагын 5,765.6 сая төгрөгийн шимтгэл, 433.9 сая төгрөгийн алданги нийт 6,199.5 сая төгрөгийг нэхэмжлэн шүүхэд шилжүүлсэн. Үүнээс 8 аж ахуйн нэгж байгууллагын 4,660.8 сая төгрөгийн шимтгэл, 4.8 сая төгрөгийн алданги нийт 4665,7 сая төгрөгийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад албадан гүйцэтгүүлэхээр өгсөн. 10 аж ахуйн нэгж байгууллагын хаяг байршил, эзэн холбогдогч олдохгүйн улмаас шүүхээс хэрэгсэхгүй болгосон бөгөөд шүүхээр эрэн сурвалжлуулахаар дахин материал бүрдүүлэн өгсөн. Шинээр нэмж өр үүсгэхгүй байх тал дээр анхаарч аж ахуйн нэгж байгууллагуудтай уулзалт, гэрээ байгуулан ажиллаж байна.<br>Оны эхний авлага 77422,6 сая төгрөг байснаас 2748 ажил олгогчийн 20240,71 сая төгргйин авлагыг бүрэн барагдуулж, 718 ажил олгогчийн 6258,13 сая төгрөгийн авлагыг хэсэгчлэн барагдуулж, 3466 ажил | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | олгогчийн 26498,85 сая төгрөгийн авлагыг барагдуулж оны эхний авлагыг 34,2 хувиар бууруулан ажиллаж байна.<br>2025 оны эхний хагас жилд шинээр 2964 ажил олгогчийн 50924,82 сая төгрөгийн авлага үүсээд байгааг ангилан судалж журамд заасны дагуу шат дараалалсан арга хэмжээг авч барагдуулан нэмж өр үүсгэхгүй байхаар анхааран ажиллаж байна. | |
| 2.1.4. | Төсөвт байгууллага болон орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын шимтгэлийн өрийг бүрэн барагдуулсан байх; | | Шимтгэлийн өргүй гарсан байх. | Төсөвт байгууллагын шимтгэлийн өргүй,<br>орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын шимтгэлийн өр 444,34 сая төгрөг байна. | Төсөвт байгууллага болон орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын шимтгэлийн өрийг бүрэн барагдуулж шинээр нэмж өр үүсгэхгүй байх талаар анхаарч ажиллах. | 2024 оны эцэст төсөвт болон орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын шимтгэлийн өр 444,34 сая төгрөг байсаныг эхний хагсас жилд бүрэн барагдуулж өргүй гарсан. Цаашид өр үүсгэхгүй байхаар сургалт орж анхааран ажиллаж байна. | 100 хувь |
| 2.1.5. | Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн дагуу нийгмийн даатгалын сангийн орлогыг бүрдүүлэх ажил зохион байгуулах; | | Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн дагуу | Нийгмийн даатгалын санд 484832,0 сая төгрөгийн орлого хуримтлуулав. | Нийгмийн даатгалын санд 538083,4 сая төгрөгийн орлого төвлөрүүлнэ. | Сангийн орлогын төлөвлөгөөг сар болон улирлаар жигд хангаж биелүүлж эхний хагас жилийн байдлаар 245192,35 сая төгрөгийн орлого хуримтлуулахаас 245265,90 | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | орлогын гүйцэтгэл 100 % хангуулна | | | сая төгрөг буюу 100,03 хувиар биелүүлэн ажиллаа. | |
| ***Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт*** | | | | | | | |
| ***Зорилт 3:*** *“Нийгмийн даатгалын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, сангийн болон үйл ажиллагааны зардлын зарцуулалтад аудит хийх, дүгнэлт зөвлөмж гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх”* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 3.1. | Байгууллагын нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг хангаж, байгууллагын цахим хуудаст болон мэдээллийн самбарт хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж, хяналт тавих; | | - Мэдээлэл байршуулалтыг 100 хувьд хүргэнэ. | Байгууллагын цахим хуудсанд мэдээлэл байршуулалт 2024 оны жилийн эцсийн байдлаар 100 хувийн гүйцэтгэлтэй байна. | Байгууллагын мэдээллийг үнэн зөв, бодитой мэдээлж мэдээллийн ил тод, нээлттэй байдал хангагдан иргэдийн мэдээлэл авах эрхийг хангаж ажилласан байна**.** | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд шилэн мэдээллийн системд 87 төрлийн мэдээллийг холбож оруулсан.. Тухайлбал<br>1. Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлын талаар 18 төрөл<br>2. Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлын талаар 7 төрөл<br>3. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлын талаар 29 төрөл<br>4. Үзүүлж байгаа үйлчилгээний талаар дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байдлын талаар 6 төрөл | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 5. Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдлын талаар 27 төрлийн мэдээ мэдээллийг https://shilen.gov.mn/ сайтад холбон ажилласан. 100 хувь байршуулан ажилласан. | |
| 3.2. | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, шилэн дансны цахим хуудаст Нийгмийн даатгалын сан, байгууллагын санхүү үйл ажиллагааны мэдээллийг хугацаанд үнэн зөв, бодитой бүрэн мэдээлж, мэдээлэл байршуултад хяналт тавих; | | - Сар бүрийн хугацаанд байршуулсан мэдээлэл 100 хувь байна.<br>- Шилэн дансны хөтлөлтийн тайлан /4/-г байгууллагын цахим хуудаст Улирал бүрийн дараа сарын 15-ны өдрийн дотор мэдээлсэн байна. | Шилэн дансны хөтлөлтийн 2024 оны нэгдсэн тайлангаар мэдээлэл байршуулалт 100 хувьтай байна. | Нийгмийн даатгалын байгууллагын санхүү үйл ажиллагаа болон сангийн мэдээллийг хуулийн хугацаанд нь үнэн зөв мэдээлж, иргэдийн мэдээлэл авах эрхийг хангаж ажилласан байна. | Шилэн дансны тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд зааснаар нийгмийн даатгалын байгууллагын тухай бүр хэсэгт- 55, сар бүр хэсэгт- 24, жил бүр хэсэгт- 3, нийт 82 мэдээг гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт холбогдох журмын 2 дугаар хавсралтад заасан маягтын дагуу https://shilendans.gov.mn/ системд 100 хувь хуулийн хугацаанд байршуулан ажилласан.<br>Нийгмийн даатгалын байгууллагын санхүү болон сангийн мэдээллийг хуулийн хугацаанд 171 мэдээллийг бүрэн байршуулж, иргэдийг үнэн, зөв мэдээллээр хангасан байхаас эхний хагас жилийн байдлаар 91 мэдээллийг 100 хувь оруулсан байна. | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| ***Зорилт 3.1:*** *“Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг ажил олгогч, даатгуулагч, иргэн болон нийгмийн даатгалын орон нутгийн нэгжид хяналт шалгалт хийж шийдвэр гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, үр дүнг сайжруулах чиглэлээр санал боловсруулах”* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 3.1.1. | Нийгмийн даатгалын багц хуулийн хэрэгжилтийг газрын даргын баталсан удирдамжийн дагуу аж ахуйн нэгж, байгууллагад болон газрын үйл ажиллагаа, сангийн зарцуулалтад хяналт шалгалт хийж илэрсэн төлбөр, зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулж ажиллах, | | - Шалгасан аж ахуйн нэгж, байгууллагын тоо, хамрагдалтын хувь, - Шалгалтад хамрагдсан нийгмийн даатгалын сангийн тоо, мэдээлэл, Илэрсэн төлбөр, зөрчлийн баргадуулалтын хувь. | Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг нийт аж ахуйн нэгж байгууллагын 20 хүртэл хувьд мөн нийгмийн даатгалын 3 сангийн зарцуулалтад дотоодын хяналт шалгалт хийж илэрсэн төлбөр, зөрчлийн 80 хувийг барагдуулж ажилласан. | Шалгалтын үр дүнг тухай бүрт тооцон газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж холбогдох шийдвэр гарган, актын барагдуулалтын мэдээ, тайланг Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газарт хүргүүлж ажилласан байна. | Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, түүний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах ажлын хүрээнд газрын даргын баталсан удирдамжийн дагуу хийж гүйцэтгэсэн ажлын талаар 1.Газрын даргын 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн баталсан 01 дугаарт удирдамжийн дагуу Нийгмийн даатгалын байгууллага, байцаагчийн дүрэмд заасан эрх үүргийн хүрээнд 2024 оны тус газарт нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан ирүүлсэн нийт 8700 ААНБ-ын тайлан (НД-7, НД-8)-г хүлээн авч баталгаажуулсан байдалд түүврийн аргаар хяналт, шалгалт хийж гүйцэтгэлээ, Хяналт, шалгалтад зөрчилтэй буюу хугацаандаа тайлангаа ирүүлээгүй, хууль, тогтоомжид заасан хугацаанд хүлээн авч баталгаажуулаагүй байж болзошгүй 3400 ААНБ-ын шимтгэл төлөлтийн тайланг хамруулан шалгасан болно. | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Шалгалтаар шимтгэл төлөлтийн тайланг хугацаа хоцроож хүлээн авч баталгаажуулсан, гарын үсэг, тамга тэмдэг дутуу, тайлангийн үлдэгдлийг баталгаажуулж тооцоо нийлсэн акт үйлдээгүй, хариуцлага тооцож хоцроосон тайланг хүлээн авч шийдвэрлээгүй, даатгуулагчийн цалин, төрлийн кодыг зөрүүтэй баталгаажуулсан зэрэг зөрчил дутагдал ирсэн байна. Дээрх зөрчлийг хяналт шалгалтын явцад арилгах, нийгмийн даатгалын улсын байцаагчийн .... дугаар албан шаардлага гардуулан өгч 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгаж ажиллах талаар анхааруулж, шаардлагын биелэлтийг 10 бүрийн 15-ны өдрийн дотор захиргаа, хяналтын хэлтэс (Т.Бат-Амгалан)-т ирүүлж байхыг үүрэг болгож ажиллалаа.<br>2.Нийгмийн даатгалын байгууллагын хэрэгжүүлж байгаа ажлын байрын стандарт, 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн газрын даргын баталсан тушаалын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэрэгжилт, чанарын менежментийн тогтолцоо MNS ISO 9001-2015 стандартын, албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан чиг үүргийн хэрэгжилтийг шалгаж шалгалтын үр, дүнг даргын зөвлөлд танилцуулж, газрын нэгж (хэлтэс, тасаг, байцаагч, ажилтнууд)-д зөвлөмж хүргүүлж цаашид хийж хэрэгжүүлэх ажлын талаар даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж алдаа, дутагдал анхаарах асуудал, цаашид хийж хэрэгжүүлэх ажлыг газрын даргын тушаалаар үүрэг даалгавар өгүүлэх санал дэвшүүлэн ажиллалаа.<br>3.Газрын даргын баталсан дотоодын хяналт шалгалт хийх удирдамжийн дагуу 2024 оны 01 сараас 2024 оны 12 дугаар сарыг дуустал хугацаанд шинээр тогтоосон тэтгэврийн тогтоолт, олголтыг шалгах ажлыг 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийг хүртэл хугацаанд хийж гүйцэтгэхээр хяналт шалгалтын ажил үргэлжилж байна.<br>4.Нийгмийн даатгалын ерөнхий газрын хяналт, шалгалтын газраас ирүүлсэн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мэдээлэл, чиглэлийн дагуу газрын даргын баталсан төлөвлөгөөт бус хяналт шалгалтын удирдамжийн хүрээнд Зоос баян суварга ХХК, Ар баян сервис ХХК-д ажиллаж байсан даатгуулагчийн шимтгэл төлсөн, цалин хөлсийг залруулсан байдалд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, цалингийн үндэслэлийг шалгаж, тодруулах холбогдох төрийн байгууллагаас мэдээлэл цуглуулах зэрэг хуулийн хүрээнд хяналт шалгалтын ажил үргэлжилж байна. | |
| 3.1.2. | Их, дээд, коллеж болон ерөнхий боловсролын дунд сургуулийн үйл ажиллагаа эрхэлдэг хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд Нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгах ажлыг зохион байгуулан үр дүнг тооцож ажиллах; | | Их, дээд, коллеж болон ерөнхий боловсролын дунд сургуулийн үйл ажиллагаа эрхэлдэг хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагуудыг шалгасан байна. | - | Нийгмийн даатгалын ерөнхий газраас ирүүлсэн жагсаалтад тусгагдсан нэр бүхий аж ахуйн нэгж, байгууллагад нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгаж, илэрсэн зөрчлийг арилгах, хуулийн дагуу шийдвэрлэх, | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн хүрээнд Хувийн их дээд сургууль болон ерөнхий боловсролын сургуулиудад хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж нийт 33 ААНБ-ыг хяналт шалгалтад хамруулж ажиллахаас 18 ААНБ-ын санхүүгийн баримтад хяналт шалгалтыг хийж улсын байцаагчийн шийдвэрийг танилцуулж, зөвлөмж, дүгнэлт өгч ажиллалаа. Шалгалтын хүрээнд 2 ААНБ-д 20,1 сая төгрөгийн төлбөр зөрчлийг илрүүлж, хяналт шалгалтын явцад төлбөр | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хариуцлага тооцох, мэргэжил арга зүйн зөвлөгөө, зөвлөмж өгч ажилласан байна. | зөрчлийн бүрэн барагдуулж ажилласан. Тус хяналт шалгалтын ажил нь цаг үеийн асуудлаас үүдэлтэй 2025 оны 10 сарыг хүртэл хугацаанд хойшлогдсон тул 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс үргэлжлүүлэн зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.. | |
| 3.1.3. | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг хувийн хэвшлийн ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд Нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгах ажлыг зохион байгуулан үр дүнг тооцож ажиллах; | | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг хувийн хэвшлийн ахуйн нэгж, байгууллагуудыг шалгасан байна. | - | Нийгмийн даатгалын ерөнхий газраас ирүүлсэн жагсаалтад тусгагдсан нэр бүхий аж ахуйн нэгж, байгууллагад нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгаж, илэрсэн зөрчлийг арилгах, хуулийн дагуу шийдвэрлэх, хариуцлага тооцох, мэргэжил арга зүйн зөвлөгөө, зөвлөмж өгч ажилласан байна. | 2025 оны 10 дугаар сард хийж гүйцэтгэхээр төлөвлөгөөнд тусгагдсан бөгөөд бэлтгэл 100 хувь ханган ажиллаж байна. | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1.4. | Ажилгүйдлийн даатгалын сангийн 2022-2024 оны орлого бүрдүүлэлт, зарцуулалтад гүйцэтгэлийн хяналт шалгалт хийж үр дүнг тооцох, тайланг заасан хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газарт хүргүүлэх; | | -Шалгалт хийсэн объектын гүйцэтгэлийн хувь<br>-Илрүүлсэн зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулах,<br>-Шалгалтын тайланг хугацаанд Хяналт шалгалтын газарт хүргүүлсэн байна. | - | Ажилгүйдлийн даатгалын сангийн бүрдүүлэлт, зарцуулалтыг шалгаж, үр дүнг тооцож, илэрсэн зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулж ажилласан байна. | Монгол Улсын засгийн газрын тогтоолын дагуу салбарын хяналтын ахлах байцаагчийн 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн баталсан 08-07/06 дугаартай “Нийгмийн даатгалын газрын ажилгүйдлийн сангийн 2022-2024 оны орлогын бүрдүүлэлт, сангийн зарлагын зарцуулалтад урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу Хан-Уул, Баянгол, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргийн нийгмийн даатгалын газрын 2022-2024 онуудад нийгмийн даатгалын сангаас олгосон 22828 даатгуулагчийн ажилгүйдлийн тэтгэмжийн бодолт, олголтод хяналт, шалгалт хийж гүйцэтгэлээ.<br>Шалгалтыг түүврийн аргаар зохион байгуулж ажилласан ба 32195 даатгуулагчийн материалыг хянаж үзэхэд ажилгүйдлийн тэтгэмж авч байх хугацаандаа ажилд орсон 148 даатгуулагчийн 179,4 сая төгрөгийг нийгмийн даатгалын санд төлүүлэх улсын байцаагчийн акт тогтоож шийдвэрлэв. Тэтгэмжийг дутуу тооцож олгосон 2 иргэний 1,2 сая төгрөгийн нийгмийн | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | даатгалын сангаас нөхөн олгохоор тус тус шийдвэрлэв. Мөн ажилд орсон, илүү авсан тэтгэмжийн тооцоолол хийх боломжгүй 431 иргэний тэтгэмжийг тодруулж төлүүлэх, хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулах талаар улсын байцаагчийн албан шаардлагыг тус тус хүргүүлж биелэлтийг сар бүрийн 10-ны өдрийн дотор НДЕГ, хяналт шалгалтын газарт ирүүлж байхыг дүүргүүдийн нийгмийн даатгалын газрын дарга нарт үүрэг өгч ажиллалаа. | |
| 3.1.5. | Нийгмийн хамгааллын салбарын хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн нэр бүхий 351 объектод төлөвлөгөөт шалгалт хийх, мэдээ тайланг нэгтгэх; | | Эрсдэл бүхий аж ахуйн нэгж байгууллагын 80 хүртэл хувийг шалгаж, илэрсэн зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулах,<br>-<br>Удирдамжийн хугацаанд | 2024 онд 33 объектод хяналт шалгалт хийж, 144,6 сая төгрөгийг зөрчил илрүүлж, албан шаардлага хүргүүлж ажилласан. | Их, дунд эрсдэл бүхий аж ахуйн нэгж байгууллагын 80 хүртэл хувийг шалгаж, илэрсэн зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулсан байна. | Нийгмийн хамгааллын салбарын хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн нэр бүхий 351 объектод хийх хяналт, шалгалтын ажил тодорхой шалтгааны улмаас 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс үргэлжлэн явагдаж байгаа бөгөөд бэлтгэл 100 хувь хангаж ажиллаж байна. | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | мэдээ тайланг нэгтгэж, тайланг Хяналт шалгалтын газарт хүргүүлсэн байна. | | | | |
| 3.1.6. | Нийгмийн даатгалын ерөнхий газраас болон хөндлөнгийн хяналт, шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалтын мэдээ, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын тайланг улирал тутамд гаргаж Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газарт хүргүүлэх, | | - Хяналт, шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалтын хувь,<br>- НДЕГ-т хүргүүлсэн тайлан, мэдээний тоо, | Шалгалтын үр дүнг тухай бүрд нь тооцон, газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж холбогдох шийдвэр гаргуулж илэрсэн зөрчлийн 80-аас доошгүй хувийн барагдуулж, НДЕГ-т мэдээг хүргүүлж ажилласан. | Шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулж, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын үр дүнг тооцож, тайланг улирал тутамд гарган Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газарт хүргүүлж ажилласан байна. | Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгах ажлын хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газраас ирүүлсэн улсын байцаагчийн актын авлагыг бууруулах ажлыг эрчимжүүлэх ажлын хүрээнд Баянзүрх дүүргийн Нийгмийн даатгалын газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн “Авлага барагдуулах нэгдсэн төлөвлөгөө”-ний дагуу НДЕГ-ын болон дотоодын хяналт шалгалтаар тогтоосон улсын байцаагчийн актын авлагыг барагдуулах ажлын хүрээнд дараах ажлыг хийж хэрэгжүүлж байна.<br>1. 13 ААНБ-тай холбоотой 168,2 сая төгрөгийг төлүүлэхээс 3 ААНБ-ын 15,1 сая төгрөгийг барагдуулж, 5 ААНБ-ын төлбөр зөрчлийг барагдуулахаар шүүхэд хандах, эрэн | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сурвалжлуулахаар шүүхэд хүргүүлээд байна.<br>2. Тэтгэврийн даатгалын санд 53 иргэнтэй холбоотой 638,5 сая төгрөг төлүүлэхээс 37 иргэний 85,6 сая төгрөг,<br>3. Ажилгүйдлийн даатгалын санд 15 иргэний 17,6 сая төгрөг төлүүлэхээс 3 иргэний 0,8 сая төгрөгийн төлбөр зөрчлийг тус тус барагдуулж ажиллалаа.<br>Цаашид иргэн, аж ахуй нэгж байгууллагатай холбоотой улсын байцаагчийн актын авлагыг барагдуулах ажлын иргэний болон захиргааны хэргийн шүүхэд хандаж шийдвэрлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.<br>Дээрх төлбөр зөрчлийн барагдалттай холбоотой мэдээ тайланг цаг тухайд нь хүргүүлж ажиллаж байна. | |
